



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 05 өдөр

Дугаар 604.

Улаанбаатар хот

Г Шалган зааварчлах ажлын мөрөөр авах зарим арга хэмжээний тухай Г

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1.Дорнод аймгийн Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагаанд хийсэн мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, шалган зааварчлах ажлын дүнгээр илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ, зөвлөмжийг хавсралтаар баталсугай.

2.Шалган зааварчлах ажлын тайландаа дурдсан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх, өмчийн харилцааны чиглэлээр батлан гаргасан зарим тогтоол, шийдвэрийг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэх, шаардлагатай тохиолдолд хүчингүй болгох арга хэмжээ авахыг Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөсүгэй.

3.Дорнод аймгийн Засаг дарга Ш.Ёл, Дорнод аймгийн Орон нутгийн өмчийн газар (Б.Алтансүх)-т дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

3.1.Шалган зааварчлах ажлын хүрээнд илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах;

3.2.Дорнод аймгийн өмчийн харилцааны чиглэлээр мөрдөж буй журам, гэрээний загвар, маягт, аргачлалыг хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн боловсруулж, эрх бүхий этгээдээр батлуулах;

3.3.Хийж гүйцэтгэсэн ажлын тайланг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс (Н.Ганболд) -т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.Доржсүрэн

Д.НАРАНГЭРЭЛ

132000630

28-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын ... оны ... сарын ...-ний өдрийн
604 дугаар тогтоолын хавсралт

**ДОРНОД АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ШАЛГАН ЗААВАРЧЛАХ АЖЛЫН ДУНГЭЭР
ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДЛЫГ АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ЖАГСААЛТ, ЗӨВЛӨМЖ**

Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (өмчлөгч), аймгийн Засаг дарга, Орон нутгийн өмчийн газар (ОНӨГ)-т өмчийн харилцааны чиглэлээр дараах арга хэмжээг авч, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах зөвлөмжийг өгч байна:

1. Орон нутгийн өмчийн газрын дүрмийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн, чиг үүргийг бүрэн тодорхойлж тусгах, боловсруулалтыг сайжруулах;

2. Орон нутгийн өмчийн газрын чадавхийг сайжруулж, албан хаагчдыг компанийн засаглал, хяналт шалгалт, хууль, эрх зүй, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүү, нягтлан бodoх бүртгэлийн чиглэлээр сургалтад хамруулж, мэдлэг чадварыг дээшлүүлэх;

3. Төрийн албаны зөвлөлийн 2023 оны "Зөвшөөрөл олгох тухай" 527 дугаар тогтоол, 2024 оны "Тогтоол, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 202 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, эрх бүхий албан тушаалтны баталсан албан тушаалын тодорхойлолтыг албажуулах, Төрийн албаны зөвлөлийн нэгдсэн бүртгэлд оруулах үйл явц удаашралтай байгаад анхаарч, шуурхай арга хэмжээ авах;

4. ОНӨГ-ын албан хаагчдын хувийн хэргийн бүрдлийг хангах, анкет, холбогдох мэдээллийг иж бүрэн байлгах ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн үнэлгээний хуудас, гүйцэтгэлийн тайланг хувийн хэрэгт оруулж баяжилтыг цаг тухай бүр хийж, хувийн хэргийн эмх цэгц, стандартыг хангах;

5. Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах, үр дүнг дүгнэх асуудалтай холбоотой гарсан Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор баталсан журам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалаар баталсан аргачлал, загварын хэрэгжилт хангалтгүй, 2024 гүйцэтгэлийн төлөвлөгөөг хүчин төгөлдөр мөрдөж байгаа журам, аргачлал, загварын дагуу боловсруулаагүй байгаад дүгнэлт хийж, энэ чиглэлээр аймгийн Засаг даргын Тамгын газраас арга зүйн зөвлөгөө, мэдээлэл өгч, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих;

6. Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгууллагын чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэхэд чиглэсэн, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэгтэй уялдахуйц зорилт, арга хэмжээ болон шалгуур үзүүлэлтийг оновчтой томъёолон илэрхийлж (хэмжигдэхүйц, биелэгдэхүйц г.м.) тусгах, мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээг тодорхой төлөвлөх, төлөвлөгөөний гүйцэтгэл, үр дүнг холбогдох журам, аргачлалын дагуу үнэн зөв дүгнэж үнэлэх;

7. Чиг үүргийн болон ажлын байрны шинжилгээ хийх замаар албан хаагчдын ажлын ачааллыг тэнцвэртэй хуваарилж, байгууллагын үйл ажиллагаа, чиг үүргийн хийдэлгүй ажиллахад анхаарах арга хэмжээг авах;

8. Орон нутгийн өмчийн газрын тушаал, шийдвэр, баримт бичгийн боловсруулалт, албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаа, баримт материал, хадгаламжийн нэгжийн хадгалалт хамгаалалт, бүртгэл, хяналтын үйл ажиллагаанд Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ыг мөрдөх, уг журамд нийцүүлэн байгууллагын үйл ажиллагааны өөрийн онцлогт тохирсон албан хэрэг хөтлөлтийн журмыг боловсруулан баталж мөрдүүлэх, энэ чиглэлээр аймгийн Засаг даргын Тамгын газар, архивын нэгжээс мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээлэл өгч, хяналт шалгалт хийх замаар архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомжийн шинэчлэлтийн хэрэгжилтийг хангуулах;

9. Хуулийн болон зохицуулалтын шаардлагуудын нийцлийг хангах;

10. Эрх зүйн баримт бичгийг шинээр болон шинэчлэн боловсруулахдаа холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах;

11. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж хуулийг хэлбэрэлтгүй дагаж мөрдөх, үүнд удирдлагын манлайлал үзүүлэх;

12. Эрх зүйн зөрчилтэй байдлаас үүдэн гарах эрсдэлийг тооцдог байх;

13. Аймгийн Иргэдийн Тэргүүлэгчдийн 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 50 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг худалдан борлуулах, ашиглуулах, түрээслүүлэх үлгэрчилсэн журам"-ыг хуульд нийцүүлэн шинэчлэн батлуулах;

14. Өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх журам, гэрээний сунгалтын загвар зэрэг асуудлыг загварчлан батлах, энэ зохицуулалтад сүүлийн үеийн технологийн шийдэл, програм хангамж зэргийг ашиглах, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын оролцоог ойлгомжтой болгох шаардлагатай;

15. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.1, 31.4-д заасан Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журамыг баталж (Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоолоор баталсан журмыг ашиглаж болно) мөрдөж ажиллах шаардлагатай;

16. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49, 50, 51 дүгээр тогтоолыг жишиглэн түрээсийн харилцааны зохицуулалтыг илүү ойлгомжтой болгож, зохицуулалтгүй харилцаа үүсгэхгүй байхад анхаарч ажиллах;

17. Мөн шүүхэд үүссэн хэрэг маргаан бүрийг хавтаст хэрэг болгож стандартын дагуу бүрдүүлэх, архивлах болон хэрэг маргааны танилцуулга, файл үүсгэж нэгтгэн цэгцлэх, Орон нутгийн өмчийн газрын дагаж мөрдөж буй дүрэм, журам, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн судалгаа гаргаж үйл ажиллагаандаа байнга ашиглах;

18. Хөрөнгө худалдах, шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхээс өмнө газрын эзэмшлийг судалж, тухайн төсвийн байгууллагад газар нь зайлшгүй шаардлагатай тохиолдолд барилга худалдахаас татгалзах, эсхүл газрыг үлдээх шаардлагагүй бол газар, барилгыг хамтад нь үнэлүүлэх шаардлагатай;

19. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх асуудал болон Аймгийн Засаг даргын захирамжаар шийдвэрлүүлэх асуудалд гарах шийдвэрийн төсөл, танилцуулгыг бэлтгэж тухайн төсөл болон танилцуулгад "боловсруулсан", "хянасан", "танилцсан", хурлаар оруулахыг зөвшөөрсөн албан тушаалтны нэр, гарын үсэг, огноог тусгаж, эдийн засгийн тооцоолол, эрх бүхий этгээдийн дүгнэлт зэрэг нэмэлт мэдээлэл, зураг, гэрчилгээ зэргийг хавсарган баримт бичгийн бүрдэл

хангаж шийдвэрлүүлэх, эдгээр баримтыг батлагдсан шийдвэрийн хамт Орон нутгийн өмчийн газрын архивын баримт болгон хадгалах;

20. Хурлын дэг, асуудал шийдвэрлүүлэх дараалал, хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэхдээ өмчийн харилцааны асуудлаар шийдвэр гаргуулахын өмнөх төсөл, төслийг хэлэлцүүлсний дараах төсөл гэсэн баримтыг бүрдүүлэх, тухайн хөрөнгийг худалдах, актлах, шилжүүлэх, үнэлэх болсон шалтгаан, үнэлгээ хийсэн үндэслэлийг нарийвчлан хянаж, тэмдэглэл хөтлөх, шийдвэрийн хавсралтад шаардлагатай мэдээллийг бүрэн тусгах, хөрөнгө шилжүүлэх болон худалдан авсан этгээдэд хүлээлгэн өгсөн акт үйлдэж байх;

21. Албан ёсны цахим хуудас дахь мэдээллийн ил тод, хүртээмжтэй, үнэн зөв, байдлыг хангаж ажиллах;

22. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 271 дүгээр тогтоолоор баталсан журмын 7-д заасан “үнэ шинэчлэн тогтоо”-той холбогдсон зохицуулалт (Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/229 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 10-Үндсэн хөрөнгө, (ж)...)-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, төсвийн байгууллагад мөрдөж, холбогдох шийдвэрийг цаг тухайд нь гаргаж байх;

23. Аймгийн ОНӨГ-ын бүтэц, орон тоонд хяналт шалгалт хариуцсан мэргэжилтний орон too батлагдсан тул албан тушаалын тодорхойлолтын дагуу хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэх, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас өгсөн мэргэжил, арга зүйн зөвлөмжийн дагуу газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд энэ талаар зорилт, арга хэмжээг төлөвлөн тусгаж хэрэгжүүлэх, орон нутгийн өмчид бүртгэлээр хяналт тавьж, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, компанийд хянан шалгалт хийх ажлыг зохион байгуулж байх;

24. Засгийн газрын 2022 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн “Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах арга хэмжээний тухай” 340 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжийг судлан хэрэгжүүлэх шаардлагатай;

25. Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-д заасны дагуу орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захиралтай “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ыг баталж мөрдүүлэх;

26. Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин хоронгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, Гүйцэтгэх удирдлага болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, компанийн санхүүгийн тайлан тэнцэл, аудитын дүгнэлт, зөвлөмжийг авч хэлэлцэн зохион байгуулалтын бүтцийг оновчтой болгох, орлогыг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах, Улсын төсөв, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, хандив, зээл тусlamжийн эх үүсвэрээр бий болсон хөрөнгийн зориулалт, зээлийн эргэн төлөлт, тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгах талаар тодорхой арга хэмжээ авах;

27. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”, 85 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам”, 86 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн хуулийн этгээдийн ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах нийтлэг журам”-ыг үлгэрчилсэн жишиг загвар болгон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд төлөөлөл хэрэгжүүлэх, орон нутгийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын сул орон тоог нөхөх үйл ажиллагааг зохицуулсан нийтлэг журмыг орон нутгийн удирдлагын эрх хэмжээний хүрээнд баталж, хэрэгжилтийг хангуулах;

28. Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр” (2023-2030 он), 2024 оны 46 дугаар тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2030 он)”-нд тусгагдсан орон нутгийн өмчийн харилцааны асуудалтай холбоотой зорилго, зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээ, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэхэд чиглэсэн ажлыг шат шатны жилийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх, эрх зүйн зохицуулалт, шаардлагатай шийдвэр гаргах асуудлаар зохих арга хэмжээ авч ажиллах, хэрэгжилтийг холбогдох шатны байгууллагад тайлагнах ажлыг зохион байгуулах;

29. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Орон сууц хувьчлах тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худагдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандaa мөрдөн ажиллах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллан, үр дүнг тооцож байх.